



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/132

Хэрлэн сум

Бүсийн уралдаан зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сэцэн ханы хүлэг морин спорт уяачдын холбоо" төрийн бус байгууллагаас ирсэн хүсэлтийг үндэслэн бүсийн уралдааны товыг хавсралтаар баталсугай.

2. Бүсийн уралдааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг "Сэцэн хааны хүлэг морин спорт уяачдын холбоо" төрийн бус байгууллагын тэргүүн (Н.Тэгшжаргал)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг уралдаан зохион байгуулагдах сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газрын дарга (цагдаагийн Дэд хурандаа Э.Жавхлантөгс)-д, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Ж.Эрдэнэбат), Хүүхэд, Гэр бүлийн, хөгжил хамгааллын газрын дарга (Х.Уртнасан), Мал эмнэлгийн газрын дарга (Л.Анхбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ



۲۳۵/۴

[illegible][illegible]



03. Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 11-ний өдрийн
1132 дугаар захирамжийн хавсралт

“СЭЦЭН ХАНЫ ХУРД-2025” УРАЛДААН

Бүсийн уралдаан зохион байгуулах газар	Огноо	Бүсийн нэр	Уралдах нас
Жаргалтхаан сум	2025.05.03-05.04	Сэцэн ханы хурд	Их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага, сонгомол дунд, сонгомол бага

АЙМГИЙН БҮСИЙН УРАЛДААН ДЭЭД 3 НАС

Бүсийн уралдаан зохион байгуулах газар	Огноо	Бүсийн нэр	Уралдах нас
Батширээт сум	2025.06.28	Хойд бүс	Азарга, их нас, соёолон
Баянхутаг сум	2025.06.28	Өмнөд бүс	Азарга, их нас, соёолон
Бор-Өндөр сум	2025.06.28	Баруун бүс	Азарга, их нас, соёолон
Өмнөдэлгэр сум	2025.06.28	Төвийн бүс	Азарга, их нас, соёолон

АЙМГИЙН БҮСИЙН УРАЛДААН БАГА 3 НАС

Бүсийн уралдаан зохион байгуулах газар	Огноо	Бүсийн нэр	Уралдах нас
Баян-Адарга сум	2025.05.10	Хойд бүс	Хязаалан, шүдлэн, даага
Галшар сум	2025.05.10	Өмнөд бүс	Хязаалан, шүдлэн, даага
Дэлгэрхаан сум	2025.05.10	Баруун бүс	Хязаалан, шүдлэн, даага
Хэрлэн сум	2025.05.10	Төвийн бүс	Хязаалан, шүдлэн, даага